

## ИНФЛЯЦИ БОЛОН МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАМААРАЛ\*

Д. ГАН-ОЧИР, Г. БОРХҮҮ

### I. Оршил

Сүүлийн жилүүдэд төв банкны мөнгөний бодлого хэрэгжүүлэх арга барил нь үнийн тогтвортой байдлыг бодлогын гол зорилгоо болгон ажиллах болсноор жилийн инфляцийн түвшин эрчимтэй буурч тогтвожих хандлагатай байхад харин мөнгөний нийлүүлэлт тогтвортой ёсөх хандлагатай байлаа.

Энэхүү инфляци, мөнгөний нийлүүлэлтийн эрс ялгаатай хандлагаас харахад инфляци, мөнгөний нийлүүлэлтийн хооронд тогтвортой хамаарал байгаа эсэх нь эргэлзээтэй. Ийм хэдий ч мөнгөний агрегатуудын хоорондын хамаарлыг гарган, инфляци мөнгөний гол гол агрегатуутдай хэрхэн уялдаа нөлөөтэй байгааг загварчилан судалснаар инфляци болон нийт мөнгөний үзүүлэлтүүдийн хамаарлыг судалсантай адил үр дүнд хүрч болно. Нөгөөтэйгүүр мөнгөний бодлогын хэрэгслүүд болон бусад шалтгаанаар мөнгөний бүтэц өөрчлөгдөхөд мөнгөний агрегатуудад харилцан адилгүй нөлөө үзүүлдэг тул инфляцид үзүүлэх нөлөөлүүдийг ялган харах бололцоог олгох юм.

Инфляцид эдийн засгийн олон хүчин зүйл нөлөөлдөг. Гэхдээ Инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хооронд тогтвортой хамаарал тод ажиглагдахгүй байх нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн системд шилжсэн манай орны хувьд бүтцийн буюу шилжилтийн инфляцитай холбоотой байх талтай.

Мөнгөний нийлүүлэлт инфляцид, инфляци эдийн засагт тодорхой хугацааны хоцролтойгоор нөлөөлдөг учраас түүнийг тодорхойлох, таамаглал дэвшүүлэх загварыг олох нь мөнгөний бодлогыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Судалгааны зорилго нь орчин үеийн төв /МБ/ банкны сүүлийн үеийн мэдээллийг ашиглан мөнгөний үзүүлэлтүүд, гол гол мөнгөний агрегатууд инфляци хоорондын хамаарлыг тодорхойлох замаар инфляци болон нийт мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлуудыг тодорхойлж, Монголын дараа саруудын инфляцийг таамаглан өмнө гаргасан хамаарал дээрээ үндэслэн үнийн түвшинг тогтвортой байлгахад мөнгөний үзүүлэлтүүдийг хэрхэн ашиглаж болохыг гаргахад оршино.

Энэ судалгааны 2 дугаар хэсэгт инфляцид нөлөөлөх хүчин зүйлс болох монетари бус, монетари хүчин зүйлийг манай орны хувьд шилжилтийн эдийн засагтай байсантай холбогдуулан дурьдсан. 3 дугаар хэсэгт мөнгөний үзүүлэлтүүдийг удирдах замаар инфляцийг тогтвожуулахад ашиглаж болох Монголбанкаас

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг үндсэн хэрэгслүүдийг энгийнээр тайлбарлах, анхан шатны ойлголт өгөх зорилгоор товч дурьдсан.

4 дүгээр хэсэг нь мөнгөний үзүүлэлтийн хоорондын хамаарлыг онолын хувьд томъёолсон. Мөнгийг бүрдүүлэгч хүчин зүйлсийн өөрчлөлтөөр мөнгөний агрегатуудад хэрхэн өөрчлөлт ордгийг гаргасан. 5 дугаар хэсэгт монетарист загвараар инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг гаргах. 6 дугаар хэсэг нь инфляцийн таамаглалын сүүлийн үед өргөн ашиглаж буй ARIMA болон VAR загвараар үнэлсэн. 7 дугаар хэсэг шинжилгээнд ашиглагдсан тоон үзүүлэлтүүдийн товч тайлбар, динамик хандлага, ADF тестийн үр дүнт тус тус оруулсан. Эдгээр тоон үзүүлэлтийг Монголбанкны вэб-сайт [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) ээс авч ашигласан бөгөөд зарим үзүүлэлтүүдийг судалгаандаа зориулан тооцоолон гарган авч ашигласан. 8 дугаар хэсэг нь загваруудын үнэлгээний үр дүнгийн тайлбар юм. Үнэлгээг хавсралтанд гаргасан байгаа. 9 дүгээр хэсэгт инфляцийн таамаглал болон мөнгөний үзүүлэлтүүдийг уялдуулах нь :Энэ хэсэгт мөнгөний үзүүлэлтээр инфляцийг тогтвортжуулах боломжийг авч үзсэн .10 дугаар хэсэгт судалгааны үр дүнт ашиглан ерөнхийд нь дүгнэсэн.

## II. Инфляцид нөлөөлөх хүчин зүйлс

Инфляцийн талаар эрдэмтдийн дунд янз бүрийн үзэл баримтлал байдаг. Ерөнхийд нь авч үзвэл инфляцид нөлөөлөх хүчин зүйлийг :

- Монетари биш хүчин зүйл
- Монетари хүчин зүйл гэж хоёр ялгаж судлах нь зүйтэй.

### 2.1 Монетари биш хүчин зүйлийн нөлөөлөл

Манай орны хувьд монетари биш хүчин зүйлийн гол шалтгаан нь :

- a) Социалист эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа үед бүтцийн хүчин зүйлээс шалтгаалах бүтцийн инфляци;
- b) Зардлын өсөлтөөс уламжилсан зардлын инфляци;

Бүтцийн инфляци буюу шилжилтийн үеийн инфляцийн хүчин зүйл нь :

1. Төвлөрсөн төлөвлөгөөт үеийн эдийн засгийн бүтэц зах зээлийн эдийн засагт гэрээслэгдсэн байдал
2. Үйлдвэрлэл зах зээлийн дангаараа ноёрхсон байдал

Нийлүүлэлтийн дарамт бүхий инфляцийн хамрах хүрээ нь Монголын нөхцөлд инфляцийн зардлын шинж давуутай байгаагаар тодорхойлогоно.

Зардлын инфляци нь дараахь хүчин зүйлээс хамааралтай.

- Түүхий эдийн нөөц, эрчим хүчний хүчин зүйл
- Эрэлтийн бүтцийн хүчин зүйл
- Нэрлэсэн цалингийн хэмжээний хүчин зүйл
- Техник, технологийн хоцрогдлын хүчин зүйл
- Аж ахуйн холбоо тасарсан хүчин зүйл
- Инфляцийн хүчин зүйл

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн системд шилжиж буй бүх орнууд шилжилт эхэлсэн даруйд гол төлөв их өндөр инфляцитай тулгарч ирсэн. Ингэж

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

инфляци хэт өссөн учир шалтгаан юу байв? харьцангуй үнийн систем /relative prices/ хяналтай үнийн орчинд маш их гажуудалтай байсан нь цахилгаан, хүнс зэрэг суурь үнийн чөлөөлөлтийн үед их хэмжээний үнийн өсөлтөөр илэрдэг. Мөн дийлэнх шилжилтийн эдийн засгуудад төсвийн тэнцэл алдагдсан байсан, СЭВ-н гадаад худалдааны систем нурсан зэрэг нь инфляцийг мөн далладаг. Институциональ талаасаа шинээр байгуулагдсан төвбанкууд мөнгөний нийлүүлэлтийг хянах зохицуулах туршлага дутсан явдал ч нөлөөлсөн.

## 2.2 Монетари хүчин зүйлийн нөлөөлөл

Инфляцийг цэвэр мөнгөний гарал үүсэлтэй үзэгдэл хэмээн тайлбарлах Монетарист хандлага. Мөнгөний эрэлттэй нийцсэн хэмжээнд мөнгөний нийлүүлэлтийг явуулахад инфляци хяналтанд байна хэмээн үздэг. Монетарист хандлага нь мөнгөний эрэлт тогтвортой байна гэдэг суурь ойлголт дээр тулгуурулах нь Монголын эдийн засгийн хувьд үнийн удаа дараагийн өөрчлөлтүүд болон банк санхүүгийн системийн хямрал зэргээс харахад хараахан биелэлээ олоогүй зүйл байж болох юм.

Монетарист онолын өрсөлдөгч урсгал болох бүтцийн гарал үүсэлтэй инфляцийн онолчид /structuralist model/ инфляцийн учир шалтгааныг хөгжиж буй орнуудын эдийн засгийн бүтцийн шинж чанараар тайлбарладаг. Иймд бүтцийн инфляцийг номлогчид нь инфляцитай тэмцэхийн тулд түүнийг үүсгэж буй нийгэм эдийн засгийн бөглөрөл гажуудлыг арилгахад эрх баригчид анхаарлаа хандуулах ёстой гэсэн байр суурийг баримталдаг.

Бидний энэхүү ажил нь инфляцийн шалтгаан түүний мөн чанарыг тодорхойлон гаргахаасаа илүүтэйгээр инфляци мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг тодорхойлох явдал болохоор инфляцид нөлөөлөх монетари хүчин зүйлийн нөлөөг илүүтэйгээр авч үзэх болно. Иймд бид дараагийн хэсэгтээ мөнгөний бодлогыг авч хэрэгжүүлэх Монголбанкны хэрэгслүүдийг товч авч үзэх шаардлагатай.

## III. Монголбанкнаас мөнгөний бодлогыг авч явуулах хэлбэрүүд

Нөөц мөнгө нь мөнгөний өсөлт нь төв банкны нийлүүлж буй нэмэгдэл нөөцийн хэмжээг харуулна. Нөөц мөнгөний хэмжээ нь Монголбанк (МБ)-ны банк хоорондын зах дээр шууд хийж буй хэлцлүүдийн дүнд эсвэл Засгийн газар (ЗГ)-ын дансны өөрчлөлт, олон улсын гэрээний нөхцлөөс шалтгаалан өөрчлөгдж болно. Шууд хэлцлүүдийн хэмжээг Монголбанк бүрэн удирдах бололцоотой бол Засгийн газрын дансны өөрчлөлт, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл зэргээс хамааран гарч буй өөрчлөлтийг удирдах боломж хязгаарлагдмал юм.

Монголбанкны шууд хэлцлүүд: төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны хэмжээг өөрчлөх, репо санхүүжилт хийх, банк болон ЗГ-т зээл олгох; алт, гадаад валют худалдан авах зэргээр нөөц мөнгөний хэмжээг нэмэгдүүлэдэг. Эдгээрээс алт худалдан авах нь төв банкны үндсэн үүрэгт ордоггүй, манай орны уламжлал, алт олборлолтыг дэмжиж ирсэн онцлог байдлаас шалтгаалсан үйл ажиллагаа.

Олон улсын санхүүгийн байгууллагын зээл: МБ зарим төслийн хөрөнгийн эрсдэлийг удирдах үүднээс дамжуулан зээллэдэг юм. Уг зээл олголт нь олон улсын гэрээний

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

дагуу зохицуулагдаж байдаг учраас МБ-ны сонирхлоос үл хамааран олгогдож, энэ хэмжээгээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

Засгийн газрын дансны өөрчлөлт : МБ-ны шийдвэрээр үүсч байгаа мөнгө биш боловч түүнтэй адил үр дагавар нь, зарим тохиолдолд илүү хүчтэй нөлөө үзүүлнэ. ЗГ гадаадаас зээл, бусад адилтгах төлбөр хүлээж авбал тэдгээрийг төгрөгт шилжүүлж дотоод төлбөр гүйцэтгэн, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлбэл гадаад төлбөр тооцоо нь ЗГ-ын төгрөгийн харилцахаар дамжин мөнгөний нийлүүлэлтэнд нөлөөлнө.

### **3.1 Монгол банкнаас авч явуулж байгаа мөнгөний бодлогын үндсэн хэрэгслүүд<sup>1</sup>**

Өнөөдрийн байдлаар Монголбанк нь өөрийн мөнгөний бодлогодоо дараахь үндсэн хэрэгслүүдийг ашиглаж байна.

#### ***1. Төв банкны үнэт цаас гаргаж, банкуудад арилжих***

Сүүлийн жилүүдийн мэдээллээс харахад Төв банкнаас явуулж буй мөнгөний бодлого харьцангуй зөвлөрсөн бөгөөд Монголбанкнаас эдийн засгийн идэвхжлийг богино хугацаанд мөнгөний нийлүүлэлтээр дэмжих талаар санаачлагатай ажилласаны үр дүнд мөнгөний өсөлтийн хурд нэмэгдэж, Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох ТБҮЦ-ны хүү буурч, банкуудын эзэмших ТБҮЦ-ны хэмжээ нэмэгдсэн үр дүн харагдаж байна.

#### ***2. Репо буюу үнэт цаас барьцаалан буцаан худалдааж авах хэлцэл хийх***

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглах илүү уян хатан хэрэгсэл болох репо арилжааг 2002 оны 7дугаар сараас эхлэн банк хоорондын зах дээр албан ёсоор нэвтрүүлсэн. Ингэж буцаан худалдан авах ерөнхий гэрээг банкуудтай байгуулсны үндсэн дээр Монголбанкны зүгээс нөөц мөнгөний хэмжээг уян хатан зохицуулах, банкуудын хувьд илүүдэл нөөцийг үр ашигтай хэлбэрт байршуулах, эсвэл түр зуурын эх үүсвэрийн дутагдлаа нөхөх зорилготой арилжаануудыг шуурхай хийх болсон.

#### ***3. Заавал байлгах нөөцийн хэмжээ тогтоож банкуудаар мөрдүүлэх***

Төв банкнаас төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулах шаардлага тавин, өдөр бүр хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилладаг.

#### ***4. Зээлийн өрийн үлдэгдэлд дээд хязгаар тогтоох***

Эрсдэл өндөртэй активт хэт их хөрөнгө оруулалт хийж, улмаар төлбөр тооцоо saatuuuldag байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн өрийн үлдэгдлийн дээд хязгаарыг улиралаар тогтоодог.

## **IV. Мөнгөний үзүүлэлтийн хоорондын хамаарал**

Энэ хэсэгт Монголбанкны зүгээс нөөц мөнгийг нэмэгдүүлэх болоод бусад мөнгөний бүтцийн өөрчлөлтийн хэлбэрүүдийг томёолоод цаашдаа уг нэмэгдэж буй мөнгө нь бусад этгээдийн шийдвэрээр мөнгөний агрегатуудад хэрхэн нөлөөлж буйг авч үзнэ.

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

Нөөц мөнгөний өсөлт нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд дөрвөн субъект оролцож шийдвэр гаргана. Эдгээр нь i) Монголбанк, ii) Банкууд, iii) Засгийн газар, iv) Олон нийт буюу иргэд, байгууллагууд (банкны харилцагчид) болно.

Загварыг ердийн тэнцлийн байдаар бүтцийг нь томъёолон симуляци хийх нь Монгол орны хувьд тогтвортгүй бүтцийн өөрчлөлтийн нөлөөг тойрох тустай арга байж болох юм. Иймд судалгааны үр дүнг загварыг симуляцитай харьцуулж болох юм.

#### **4.1 Мөнгөний бүтэц, өөрчлөлтийн эх үүсвэр, хамаарах хүчин зүйлс**

Мөнгөний нийлүүлэлт хэрхэн өөрчлөгдж байгааг харуулахын тулд түүний бүрдлүүдийн хоорондын хамаарал, тэдгээрийн зах зээлийн бусад хульсагчдаас хамаарч буй байдал зэргийг юун түрүүн судлах нь чухал болж байна.

$$M0_t = CR_t + BR_t \quad (1)$$

$$BR_t = RR_t + RE_t + FR_t + Cash_t \quad (2)$$

$$CIC = CR_t + Cash_t \quad (3)$$

$$M1_t = CR_t + DD_t \quad (4)$$

$$QM_t = TD_t + FD_t \quad (5)$$

$$M2_t = M1_t + QM_t \quad (6)$$

M0- нөөц мөнгө, CR- банкнаас гадуурх мөнгө, BR- банкуудын нөөц, RR- заавал байлгах нөөцийг, RE - илүүдэл нөөц, FR- гадаад валютын нөөц, Cash- касс дахь бэлэн мөнгөний нөөц, CIC- гүйлгээнд байгаа мөнгө, M1- нөөц мөнгө, QM- бараг мөнгө, TD- хугацаат хадгаламж, DD- харилцах дахь мөнгө, FD- гадаад валютын хадгаламжыг тус тус тэмдэглэсэн.

Бодлого хэрэгжүүлэгч (Төв банк ) нь заавал байлгах болон илүүдэл нөөцийг өөрчилснөөр нөөц мөнгийг өөрчилж чадах боловч түүний бүтцийг банкуудын шийдвэр, харилцагчдын сонирхол тодорхойлоно. Нөөц мөнгө өөрчлөгдсөнөөр банкууд өөрсдийн активдаа өөрчлөлт оруулж, тэдний олгох зээл, гадаад валютын хэмжээ зэрэг бүтээгдэхүүнүүд, тэдгээрийн үнүүдийг өөрчилнө.

Энд нөөц мөнгийг бүрдүүлэгч банкуудын нөөцөд нөөлөөтэй байж болохуйц хэсгүүдийг дараахь байдлаар тодорхойллоо<sup>1</sup>.

$$BR_t = \psi(DD_{t-1} + TD_{t-1}, Cash_{t-1}) \quad (7)$$

Монголбанкнаас үүсгэсэн мөнгө нь төв банк дахь банкуудын дансдыг нэмэгдүүлэн илүүдэл нөөцийг өсгөөд эдийн засгийн боломжийн хэрээр зээлийн өрийн үлдэгдлийг нэмэгдүүлнэ.

Тэгвэл нөөц мөнгөний өсөлт нь илүүдэл нөөц, банкнаас гадуурх мөнгө, банкууд дахь харилцах дансдын үлдэгдлийг нэмэгдүүлнэ. Нөөц мөнгө нэмэгдэх нь шууд DD-г нэмэгдүүлдэг бол бусад тохиолдолд зээлийн өсөлт гол үүрэг гүйцэтгэнэ.

$$\Delta M0 \rightarrow [\Delta CR, \Delta DD]$$

Үүний  $\Delta CR$  нь цалин, бусад орлого мэтийн хэлбэрээр иргэд жижиг хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд очдог гэж үзвэл тодорхой хугацааны дараа мөн л сардаа багтааж хэрэглээний бараа худалдан авч, байр, цахилгаан, дулааны үнийг төлж

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

харилцахыг нэмэгдүүлнэ. Шууд ашиглагдахгүй хэсэг нь төгрөгийн болон валютын хадгаламжийг өсгөнө.

$$\Delta CR \rightarrow [\Delta DD, \Delta TD, \Delta FD]$$

Харин  $\Delta DD$  нь борлуулалтын орлого болон бусад хэлбэрээр аж ахуйн байгууллагуудын орлогыг нэмэгдүүлсэн гэж үзвэл цалин болон бусад бэлэн төлбөр гүйцэтгэснээр бэлэн мөнгийг, бусад байгууллагуудад төлбөр гүйцэтгэн харилцахыг, үлдсэн хэсэг нь байгууллагын санхүүгийн нөөц болон төгрөг болон валютын хадгаламжийг нэмэгдүүлнэ. Эдгээр нь бүгд сардаа багтана гэж үзнэ.

$$\Delta DD \rightarrow [\Delta CR, \Delta DD, \Delta TD, \Delta FD]$$

Мөн төв банкнаас үүсгэсэн мөнгө нь мөнгөний үржүүлэгчийн нөлөөгөөр банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, зээл олгох чадварыг нь өсгөн улмаар харилцахын илүү том өсөлтийг бий болгох ёстой.

Эдгээрээс хараад хадгаламж (TD) нь банкнаас гадуурх мөнгө (CR), банкууд дахь харилцах дансны үлдэгдлээс (DD) хамааран өсөх бөгөөд хөрөнгө эзэмшигч нь хадгаламжаа нэмэгдүүлэх шийдвэрийг хүүгийн хувь хэмжээнээс хамааруулан гаргах тул хүүнээс мөн хамаарна.

Ханшны өөрчлөлт, түүний хүлээлт нь төгрөгийн болон валютын хадгаламжийн хооронд хөрөнгийн шилжилт бий болгоно. Ерөнхийдөө хөрөнгийн багцын аль нэгнийнх нь ашгийн норм нэмэгдэхэд тухайн багцын эрэлт өсч, бусад багцын нийлүүлэлт нэмэгдэн үнэ нь буурах, улмаар ашгийн норм тэнцвэржих ёстой. Тэгвэл валют ханш нь FR, DD хоёуланд нь нөлөөлнө. Ингээд төгрөгийн болон валютын хадгаламжийг тодорхойлох хувьсагчдыг дараахь байдлаар тодорхойлж болох юм.

$$TD_t = f(CR_{t-1}, DD_{t-1}, ER_{t-1}) \quad (8)$$

$$FD_t = \phi(CR_{t-1}, DD_{t-1}, ER_t, mm_t) \quad (9)$$

i нь хадгаламжийн нэрлсэн хүүг, ER нь валютын ханшийг тэмдэглэсэн.

Үүнээс гадна бэлэн мөнгө, харилцах нь бие биендээ нөлөөлөх бөгөөд ТБҮЦ, репо болон алт худалдан авсны төлбөр, гадаад валютын арилжаа зэрэг төв банктай хийсэн арилжаа аль алинд нь нөлөөлнө. Эдгээрийн оруулан бараг мөнгө, харилцахын функцийг дараахь байдлаар авлаа.

$$QM_t = \varphi(DD_{t-1}, CR_{t-1}, mm_t, BR_{t-1}, FD_{t-1}, CBBR_{t-1}) \quad (10)$$

$$DD_t = \vartheta(CBB_{t-1}, CR_{t-1}, BR_{t-1}, ER_{t-1}, i_{t-1}) \quad (11)$$

Тэгшитгэл (11) нь мөнгөний гол үзүүлэлтүүдийн нэг болох бараг мөнгөнд бэлэн мөнгө болон банкаар дамжин гүйлгээнд байгаа мөнгөний бүтцээс хэр хамааралтай тодорхойлох үүднээс эдгээр хувьсагчдыг сонгон авсан.

### Хоцрогдлын lag-г тодорхойлох /Determining the Lag Length/

Бидний хоцрогдлын хамааралыг тодорхойлох тэгшитгэл дараахь хэлбэртэй байгаа гэж үзвэл :

$$y_t = \alpha + \beta_0 x_t + \dots + \beta_N x_{t-N} + e_t$$

Энд бидний тодорхойлох зүйл бол N хэд байхыг тодорхойлох явдал юм. Хэрвээ N-г үл мэдэгдэх гэж үзэж байгаа бол түүнээс их байх M-г сонгож авч чаддаг гэе./M>N/

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

$$\sigma_n^2 = \frac{SSE_n}{T-n-2} \quad \lambda_i = \frac{SSE_{M-i} - SSE_{M-i+1}}{\hat{\sigma}_{M-i+1}^2}$$

$$H_0^g : N = M - i \quad \hat{N} = M - i + 1$$

эндээс  $F(1, T) \prec \lambda_i$  байх  $\hat{N}$  нь хоцролтын урт /lag/ байна.

Энд: SSE □алдааны квадратуудын нийлбэр, i- тестийн индекс, Т-нийт түүврийн тоо,

Мөн өөр нэг арга нь хоцролтын утгыг өөрчлөх замаар тэгшитгэлээ үнэлж, тус бүрийн хувьд Adjusted correlation хамгийн их,AIC шинжүүр хамгийн бага,SC шинжүүр хамгийн бага байх тэрхүү lag-г сонгож болно./ эдгээр шинжүүр нь хойно байгаа/

## V. Инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг гаргах

Бид дээрх хэсэгт мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлын тодорхойлсон болохоор мөнгөний нийлүүлэлт инфляцийн загварыг тодорхойлсаноор инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хамаарлын тодорхойлж болох юм.

### **Инфляцийн монетарист загвар**

Өөрийн ажлын зорилготой уялдуулан инфляци мөнгөний талын гол гол үзүүлэлтүүдтэй хэрхэн хамааралтай байдлыг гаргах үүднээс дараахь байдлаар загварчилж болох юм.

Инфляцийн монетарист хандлагыг дараахь функциэр илэрхийлье:

$$\inf = \alpha_1 + \alpha_2 M_{t-n} + \alpha_3 Y + \alpha_4 C$$

Үүнд:

CPI- Хэрэглээний үнийн индекс буюу инфляци

$M_{t-n}$  - Нийт мөнгөний жилийн өсөлт

Y-Бодит орлогын жилийн өсөлт

C- Бэлэн мөнгө гар дээрээ барихын алдагдсан боломжийн өртөг

Дээхи загвар нь дараахь онцлогуудтай. Нэгдүгээрт, загварт M буюу нийт мөнгө, түүний хугацааны хоцролттой хувьсагчид байгаа нь үнийн өөрчлөлтөнд мөнгөний нийлүүлэлтийн хугацааны хоцролттой нөлөө /lagged impact/ байж болохыг харуулна. Хоёрдугаарт, сүүлийн зүйл анги болох С нь үнийн хүлээлтийн нөлөө байж болохыг үзүүлнэ. Өнгөрсөн цаг хугацааны өндөр инфляци нь ирээдүйд мөн үлэмж хэмжээний үнэгүйдлийн хүлээлтийг үүсгэнэ. Гуравдугаарт, манайх шиг жижиг бөгөөд нээлттэй эдийн засаг учраас дээрх загварт ханшийг ч нэмж болох талтай. Дөрөвдүгээрт, Төв банкны бодлогын гол хэрэгслүүдийн нэг болох ТБҮЦ-ны хүү нөлөөлөх талтай.

$$\inf = \alpha_1 + \alpha_2 M_{t-n} + \alpha_3 Y + \alpha_4 C + \alpha_5 e + \alpha_6 r$$

e -валютын ханш; r-ТБҮЦ-ны хүү

Энэхүү судалгаа нь манай орны инфляцийн шалтгаан мөн чанарыг тайлбарлахаасаа илүүтэйгээр мөнгөний үзүүлэлт түүний хамааралыг тодорхойлох явдал болохоор энэ судалгаандаа монетарист загварыг авч тооцсон.

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

Энэ хэсэгт Монголын эдийн засгийн 1999.06-2003.12 хугацааны саруудын зарим үзүүлэлтүүд дээр Монголд инфляцийг тодорхойлогч хүчин зүйлсийг гаргаж тогтоох, эмпирик тооцоолол хийлээ.

Зорилго бол мөнгөний талын үзүүлэлтүүд нь инфляцид нөлөөлдөг эсэхийг тогтоох, түүнчлэн Granger causality тестиийн тусламжтайгаар мөнгөний үзүүлэлтийн өсөлт үнийн өсөлтийн  $dM_{t-p}$  болж өгдөг, мөн эргээд үнийн өсөлт нь мөнгөний өсөлтийн  $dCBBR_{t-w}$  эсэхийг тогтооход оршино.

Инфляци болон M0, M1 болон QM, CR, M2 мөнгөний болон тэдгээрийн өсөлтийн уялдаа харьцаа, инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс гэж үзэж болох ханш, ТБҮЦ-ны хүү, мөнгөний нийлүүлэлтийн уялдаа харьцааг тогтоох шаардлагатай.

$$\inf_t = \theta_1 + \sum_{i=1}^l \theta_2 \inf_{t-i} + \sum_{p=1}^k \theta_3 dM_{t-p} + \sum_{h=1}^s \theta_4 dER_{t-h} + \sum_{w=1}^T \theta_5 dCBBR_{t-w} + \eta_t$$

Энд:  $dX = (X - X(-1)) * 100 / X(-1)$

$dM$ - ээр дараахь мөнгөний үзүүлэлтүүдийг авсан

$dM0_{t-p}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-p$ ) сарын нөөц мөнгөний сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dM1_{t-q}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-q$ ) сарын M1 мөнгөний с

арын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dM2_{t-j}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-j$ ) сарын M2 мөнгөний сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dQM_{t-w}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-w$ ) сарын бараг мөнгөний сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dCR_{t-u}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-u$ ) сарын банкнаас гадуурх мөнгө мөнгөний сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dER_{t-h}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-h$ ) сарын валютын ханшны сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

$dCBBR$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-w$ ) сарын ТБҮЦ-ны хүүгийн сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

Дараахь параметруудийн эдийн засгийн утгын урьдчилсан таамаглалыг дэвшүүлэн шалгая. Үүнд :

- М1эсвэл M2 мөнгөний өөрчлөлт нь инфляцийг тодорхойлогч гол хүчин зүйл мөн<sup>1</sup>. Эдгээрийн өсөлт нь инфляцид эерэгээр нөлөөтэй байдаг тул өмнөх коэффициент нь эерэг байна.
- Монголын эдийн засгийн нээлттэй байдлыг харгалзан төгрөг, ам долларын ханшийн хэлбэлзэл инфляцид нөлөө үзүүлж болох талтай,
- Мөнгөний нийлүүлэлтийн хугацааны хоцролтой үзүүлэлтүүд нь хэсэг хугацааны дараа инфляцид нөлөөлдөг.
- Инфляцийн хүлээлт нь инфляцийн урьд өмнөх туршлагаас үүдэлтэйгээр бий болдог /adaptive inflationary expectation/
- Төв банкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох ТБҮЦ арилжих болсноор ТБҮЦ-ны хүүгээр дамжуулан үнийн тогтвортой байдлыг хангах гол арга зам болж байгаа.

<sup>1</sup> Mishkin, The Economics of money, Banking and Financial Markets p.665

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

- Монголын эдийн засагт сүүлийн 10 жилд гарсан бүтцийн өөрчлөлтүүд /монетари бус хүчин зүйл/-ээс шалтгаалан регрессийн үр дүн тодорхой үнэн зөв гаражгүй байж болох талтай. Гэхдээ МБ-ны мэдээлэл сайжирсан 1999-2003 оны мэдээлэл ашиглан тооцох хэдий ч нөгөө талдаа мэдээллийн интервал цөөнөөс бүрэн үр дүн өгөхгүй байх магадлалтай.

Инфляци болон мөнгөний гол гол үзүүлэлтүүдийн аль нь алиныхаа шалтгаан болж байгааг шалгахдаа дараахь тест шалгуурыг ашиглана.

### Granger-Sims F тест

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өсөлт нь ХҮИ-н өөрчлөлтийн учир шалтгаан болдоггүй гэсэн гипотезийг шалгахын тулд дараахь тэгшитгэлээр шалгасан.

$$\inf_t = \alpha_1 + \alpha_2 \inf_{t-1} + \dots + \alpha_{12} \inf_{t-12} + \alpha_{13} M_{t-1} + \dots + \alpha_{24} M_{t-12}$$

$M_{t-\sigma}$ -Мөнгөний агрегатуудыг ерөнхийд нь ганц үсгээр төлөөлүүллээ.

$\inf_{t-i,d,k,g,b}$  - хугацааны индексүүдэд харгалзах ( $t-i,d,k,g,b$ ) саруудын хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт, тэдгээрийн lag

Шалгахдаа:

$H_0$  таамаглал нь Мөнгөний үзүүлэлтийн өсөлт нь үнийн өсөлтийн шалтгаан болдоггүй үед:  $\alpha_{12} = \alpha_{13} = \dots = \alpha_{24}$  таамаглалыг шалгана.

$$\lambda = \frac{SSE_r - SSE_u}{p\hat{\sigma}_{11}} \quad \hat{\sigma}_{11} = \frac{SSE_u}{T-2k-1}$$

Энд чөлөөний зэрэг нь :  $T-2k-1$ ,  $\lambda$ -н утгыг  $F_{(k, T-2k-1, 0.05)}$  тестээр дээрх таамаглалыг шалгана. Эсрэгээр нь ХҮИ-н өсөлт нь мөнгөний өсөлтийг далладаг гэсэн таамаглал шалгахдаа :  $H_0 : \alpha_1 = \alpha_2 = \dots = \alpha_{12}$

## VI. Инфляцийн таамаглал

### Таамаглал (forecasting)-ын онолын түүх, инфляцийг таамаглал хийх арга зам

1983 онд Америкийн эдийн засагчид болох Маз, Рогов нар ирээдүйг таамаглах анхны оролдлогыг хийж байжээ. Тэдгээрийн гаргасан загварыг эконометрикийн онолд **Simultaneus equation model** гэсэн нэрээр алдаршжээ. Энэхүү загвар нь алдааны утгаа тооцдоггүйгээс алдаанд хүргэдэг байна.

1994 онд **Simultaneus equation model**-ийн алдаатай талыг сайжруулсан Box Jenkins-ийн аргыг дэлхий нийтээрээ хэрэглэх болсон байна. Гэтэл энэхүү арга нь хэдийгээр алдааны нөлөөллийг авч явдаг боловч зөвхөн стационар өгөгдөл дээр үндэслэн forecasting хийдэг.

Энэ талын алдааг залруулж гарч ирсэн загвар нь одоо тооцоолол хийх ARIMA загвар юм. Гэхдээ энэ загварт дутагдалтай тал байдаг нь хамаарах хувьсагчид нөлөөлөх хүчин зүлсийн нөлөөллийг тооцдоггүй талтай. ARIMA загвар нь нэг чиглэлийн загвар бөгөөд авторегресс, интеграцийн зэрэг, шаалсан дундажаас хамаардаг. Энэ завар нь хэдийгээр энгийн боловч оновчтой сайн таамаглал хийдэг. Тиймээс ARIMA загварыг суурь болгон, бусад инфляцийн загварыг харьцуулдаг

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

1980 онд Christopher Sims шинэ макро эконометрикийн загвар болох олон хүчин зүйлсийн ирээдүйн утгыг тооцож чадах вектор авторегресс (VAR) загвар эконометрикт хүч түрэн орж ирсэн.

Инфляцийг таамаглах олон загварууд байдаг байна. Жишээ нь, Филлипсийн муруйн загвар, markup загвар, индикатор загвар, мөнгөний нийлүүлэлтийн функцийн загвар, ARIMA, VAR загвар гэх мэт. Бид энэ хэсэгтээ инфляцийн таамаглалыг эконометрикийн салбарт сүүлийн үед хүч түрэн орж өргөн хэрэглэгдэж байгаа ARIMA болон VAR загвараар гүйцэтгэх болно.

### **Инфляцийн таамаглалын олгох давуу тал**

- Инфляцийн ирээдүйн хүлээлтийг таамагласнаар хөрөнгөө зөв байршуулах боломж
- Инфляцийг тодорхой түвшинд барихаар олон нийтэд зарлах бололцоо,
- Ирээдүйн мөнгөний бодлогыг төлөвлөх, түүнийгээ хянах,
- Инфляцийн эдийн засагт нөлөөлөх нөөлөөллийг урьдчилан тооцох,
- Энэ төрлийн таамаглал хийснээр хамгийн том давуу тал бол бодлого боловсруулагчид ирээдүйд мөнгөний үнийн тогтвортой байдлыг хангах зохистой бодлого авч явуулж чадах юм.

## **6.1 ARIMA загвар**

### **Autoregressive (AR) загвар :**

Эдийн засгийн аливаа хүчин зүйл нь өмнөх үеэсээ өндөр хамааралтай байдаг бөгөөд үүнийг эдийн засагт инерци гэдэг ойлголтоор авч үздэг. Эдийн засгийн инерци ажиглагдах хувьсагчдын хувьд инерцийг нь ашиглаж хамаарагч хувьсагчаа өөрийнх нь хугацааны хоцрогдоор тайлбарладаг загварыг AR загвар гэдэг. Манай таамаглах объектын хувьд дараахль байдлаар тодорхойлогдоно.

$$inf_t = \delta_0 + \delta_1 inf_{t-1} + \delta_2 inf_{t-2} + \delta_3 inf_{t-3} + \dots + \delta_n inf_{t-n} + e_t \quad e_t \approx N(0; \sigma^2)$$

### **Moving average (MA) загвар:**

Аливаа загварын алдаа нь хамаарагч хувьсагчид нөлөөлөх хүчин зүйлсийг оруулаагүйн алдааг дотроо агуулж байдаг болохоор хамаарагч хувьсагчийг тайлбарлах асар их мэдээллийг агуулж байдаг. Иймд хамаарах хувьсагчаа өмнөх үеийн алдаагаар нь тайлбарладаг загварыг MA загвар гэдэг.

$$\pi_t = \theta_0 + \theta_1 e_{t-1} + \theta_2 e_{t-2} + \theta_3 e_{t-3} + \dots + \theta_m e_{t-m} + v_t = \sum_{m=1}^m (\theta_0 + \theta_m e_{t-m}) + v_t \quad v_t \approx N(0; \sigma^2)$$

### **ARMA загвар**

Эмпирик судалгааны үед дээр үзсэн хоёр загвар нь тус тусдаа биеэ даан орших нь тийм элбэг тохиолдохгүй. Иймд AR загварын хамаарах хувьсагчид нөлөөлөх инерцийн нөлөө болон MA загвараас хамаарах хувьсагчид нөлөөлөх алдааны /бусад хүчин зүйл шок/ утгыг хамтад нь илэрхийлж чадах ARMA загвараа гаргаж авна. ARMA (n,m) загвар нь:

$$inf_t = \phi_0 + \delta_1 inf_{t-1} + \delta_2 inf_{t-2} + \dots + \delta_n inf_{t-n} + \theta_1 e_{t-1} + \theta_2 e_{t-2} + \dots + \theta_m e_{t-m} + \varepsilon_t \quad \varepsilon_t \approx N(0; \sigma^2)$$

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

Хэрэв үнэлгээнд ашиглах өгөгдлүүд стационари байвал бид ARMA загварыг сонгоно. Гэвч эдийн засгийн системээс тодорхойлогдох ихэнх түүхэн өгөгдөл нь ихэнхдээ стационари бус байдаг тул integrated процесс болж ARIMA загварыг ашигладаг.

## 6.2 VAR загвар

VAR загвар нь  $n$ -тэгшитгэл,  $n$ -хувьсагчдын одоогийн ба хоцролттой утгуудаар тайлбарлагддаг. Энэхүү энгийн загвар нь олон хувьсагчийн баялаг динамикуудыг системтэйгээр харуулдаг. VAR загварыг өгөгдлийг тайлбарлах, таамаглах, бүтцийн гаргалгаа, бодлогын шинжилгээ хийхдээ ашигладаг бөгөөд өгөгдлийг тайлбарлах, таамаглахдаа VAR нь хүчтэй бөгөөд эдийн засгийн бүтцийн болон бодлогын шинжилгээг сайн хийдэг эсэх нь эргэлзээтэй гэж үздэг байна.

VAR загвар нь хамарагч хувьсагчийг бусад нөлөөлөгч хүчин зүйлээр тайлбарлагдагаараа давуу тал тайлтай. Энэ загварт хүчин зүйлүүд тус тусдаа тэгшитгэлээр илэрхийлэгдэх бөгөөд нэг нэгэндээ хугацааны хоцрогдоороо нөлөөлдөг гэж үздэг. Мөн экзоген хүчин зүйлийг оруулж

болдог. Манай таамаглах объектын хувьд :

$$\left\{ \begin{array}{l} \inf_t = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{t-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} ER_{t-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} M2_{t-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} r_{t-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} QM_{t-j} + e_t \\ ER_t = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{t-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} ER_{t-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} M2_{t-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} r_{t-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} QM_{t-j} + w_t \\ M2_t = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{t-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} ER_{t-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} M2_{t-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} r_{t-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} QM_{t-j} + u_t \\ QM_t = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{t-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} ER_{t-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} M2_{t-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} r_{t-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} QM_{t-j} + v_t \\ r_t = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{t-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} ER_{t-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} M2_{t-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} r_{t-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} QM_{t-j} + \varepsilon_t \end{array} \right.$$

Загваруудын хувьд  $h$  үеийн дараахъ таамаглалын утга нь дараахъ хэлбэрээр тодорхойлогдоно.

### ARIMA(m,n)

$$\inf_{T+h} = \phi_0 + \delta_1 \inf_{T+h-1} + \delta_2 \inf_{T+h-2} + \dots + \delta_p \inf_{T-n+h} + \theta_h e_T + \dots + \theta_m e_{T-m+h} + \varepsilon_t$$

### VAR

$$\inf_{T+h} = \vartheta_0 + \sum_{d=1}^k \vartheta_{1t-d} \inf_{T+h-d} + \sum_{P=1}^S \vartheta_{2t-p} \hat{ER}_{T+h-p} + \sum_{i=1}^n \vartheta_{3t-i} \hat{M2}_{T+h-i} + \sum_{g=1}^S \vartheta_{4t-g} \hat{r}_{T+h-g} + \sum_{j=1}^m \vartheta_{5t-j} \hat{QM}_{T+h-j} + e_t$$

ARIMA болон VAR загварын хувьд таамаглалын хувьд итгэх интервал нь :

$$\hat{\inf}_{T+h} \pm z_c \cdot (\text{forecast error variance})^{\frac{1}{2}}$$

Энд:  $z_c$  -  $\alpha/2$  итгэх түвшин дэх  $N(0,1)$  нормаль тархалтын утга,  $\hat{\pi}_{T+h}$  - загвараас олдож буй таамаглалын утга,

### Загвараа сонгох

Загваруудын эконометрик үнэлгээг хийж загвараа сонгоходо дараахъ шинжүүрүүдийг гол болгон сонгоно.

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

### AIC (Akaike information criterion ) шинжүүр:

AIC шинжүүр нь түүврийн хувьд хамгийн сайн төлөөлж чадаж байгаа загварыг тодорхойлоход ашиглдаг шинжүүр. Томъёо нь дараахь хэлбэрээр тодорхойлогдоно.

$AIC(n) = \ln \tilde{\sigma}_n^2 + \frac{2n}{T}$  Загвар бүрийн хувьд үнэлгээг хийж олж авсан AIC шинжүүрийн хамгийн бага утгатай нь хамгийн төлөөлөх чадвар сайтай загвар байна.

### SC (Schwarz criterion) шинжүүр:

SC шинжүүр нь түүврээс гадуурх үнэлгээ хийхэд өөрөөр хэлбэл таамаглал хийхэд алдааны вариацын утгыг илэрхийлдэг. Томъёо нь :

$SC(n) = \ln \tilde{\sigma}_n^2 + \frac{n \ln T}{T}$  Загвар бүрийн хувьд үнэлг олж авсан SC шинжүүрийн хамгийн бага утгатай нь хамгийн бага алдаатай загвар байна.

## VII. Тоон үзүүлэлтүүд

МБ-ны сар бүрийн статистикийн мэдээлэлд гарсан тоон үзүүлэлтүүдийн Монголбанкны вэб-сайтаас авч ашигласан. Монгол улс 1990-ээд оноос шилжилтийн байдалтай байсан тул эдийн засагт бүтцийн нөлөөллүүд байсан, Монголбанкны мэдээлэл сайжирсан зэрэг үндэслэлээр 1999.06-2003.12 үзүүлэлтүүдийг авсан.

Тэгшитгэлүүд болон хамаарлыг үнэлэхдээ дээрх хугацааны саруудын мэдээллийг ашиглан эконометрикийн Eviews3.1 программаар үнэлгээ хийллээ. Хүүний үзүүлэлтүүд хувиар, мөнгөний үзүүлэлтүүд тэрбум төгрөгөөр, инфляци нь сар бүрийн,  $D_g$ -dammy хувьсагч

### Үзүүлэлтүүд :

Cash - банкуудын касс дахь бэлэн мөнгө

CPC - Гүйлгээнд байгаа мөнгө

DD -

банкуудын харилцах

M0 - нөөц мөнгө

TD - банкуудын төгрөгийн хугацаатай хадгаламж

FR - банкуудын гадаад валютын хадгаламж

M1 - бага мөнгө

CR - банкаас гадуурх мөнгө

M2 - мөнгөний нийлүүлэлт

ER - төгрөгийн ам.доллартай харьцах ханш

I - банкуудын тухайн сард олгосон зээлийн хүү

CBBR - төв банкны үнэт цаасны хүү

QM - бараг мөнгө

mm - мөнгөний үржүүлэгч /мөнгөний нийлүүлэлт нөөц мөнгөний харьцаа/

CBB - МБ-аас гаргасн үнэт цаас

inf - Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн сарын өөрчлөлт үзүүлэлт

inf0 - Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн оны эхнээс үзүүлэлт

dciic - Гүйлгээнд байгаа мөнгөний өсөлт

dcr, dm1, dm0, dm2,dqm- банкаас гадуурх мөнгөний өсөлт, бага мөнгөний өсөлт, Нөөц мөнгөний өсөлт, нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, бараг мөнгөний өсөлт

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

Дээрх хувьсагчдыг Монголбанкны сар болгон гаргадаг мэдээлэл болон вэб сайтаас авч ашиглалаа. Харин зарим гардаггүй үзүүлэлтүүдийн хувьд энэ ажлын хүрээнд дээрх мэдээллүүдийг ашиглан тооцоолж хэрэглэлээ.


Регрессийг бодохоос өмнө тоонуудын time series properties шинж чанарыг шалгах ёстой. Хэрэв үзүүлэлт маань стационар бус байх тохиолдолд үүсэх шок нь байнгын шинж чанартай өөрчлөлтийг үүсгэдэг. Харин тоон үзүүлэлт стационар байвал үүсэх ямарваа шокийн үйлчлэл хэсэг хугацааны дараа намдан дундаж түвшиндээ эргэн очдог.

Энэ ажилд ашиглагдсан дээрх үзүүлэлтүүдийн динамик эгнээ /эндоген үзүүлдэлт/-г зураг 1-д харуулан, эдгээр үзүүлэлт бүрийн стационар эсэхийг ADF тестээр шалган үр дүнг хүснэгт-1-ээр харуулав.


ADF тестиийн тохиромжит lag-н уртыг сонгохдоо Schwarz criterion (SC) хамгийн бага байхаар тусад нь сонгож авсан. Судалгаанд хамрагдсан lnbr, lncash, lncbb, lner, lni, M0, M1, M2, QM, inf, үзүүлэлтүүд 1%-ийн ач холбогдлын түвшинд I(0) процесс буюу тогтвортой, харин inf0 үзүүлэлт 5 %-н түвшинд I(0) байж, бусад үзүүлэлтүүдийн хувьд нэгж язгууртай байна гэсэн  $H_0$ :  $\rho = 1$  таамаглалыг няцааж байгаа учир тогтвортой бус буюу I(1) процесс болохыг хүснэгт 1-ээс харж болно. Харин эдгээр бүх үзүүлэлтүүд 1-р эрэмбийн ялгаварын хувьд  $H_0$  таамаглалыг 1%-ийн ач холбогдлын түвшинд няцааж байна.

**Жич:** Энд хүүгийн үзүүлэлтүүд хувиар, бусад үзүүлэлт тэрбум төгрөгөөр тооцололд орсон болно.


Зураг1а. Үзүүлэлтүүдийн динамик эгнээ /эндоген үзүүлэлтүүд/




\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.



Зураг16. Үзүүлэлтүүдийн динамик эгнээ /Эндоген үзүүлэлтүүд/




\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.



\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

**Зураг1в. Үзүүлэлтүүдийн динамик эгнээ /Эндоген үзүүлэлтүүд/**



\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

**Хүснэгт 1. ADF тестиийн үр дүн : 1999.06-2003.12**

Дэс дугаар	Үзүүлэлт	Интегрэйшин эрэг	ялгаваргүй						1-р түвшний ялгавар					
			lag	SC	ADF	Шалгуур	Стационар эсэх	lag	SC	ADF	Шалгуур	Стационар эсэх		
1	lnbr	I(0)	1	-1.47	-4.37	-4.13	T							
2	lncash	I(0)	2	0.77	-4.81	-4.13	T							
3	lncbb	I(0)	0	-0.36	-4.69	-4.13	T							
4	lncbbr	I(1)	0	0.21	-3.37	-4.13	Y	0	0.34	-8.3	-3.56**	T		
5	lnciic	I(1)	0	-2.05	-3.14	-3.49	Y	0	-1.95	-7.34	-3.56**	T		
6	lncr	I(1)	1	-2.12	-3.29	-4.13	Y	0	-2.07	-6.17	-4.27**	T		
7	lndd	I(1)	0	-2.07	-3.04	-4.13	Y	0	-7.99	-7.61	-3.56**	T		
8	lner	I(0)	1	-6.56	-5.27	-4.13	T							
9	lnfr	I(1)	0	-2.67	-0.99	-3.49	Y	0	-2.71	-7.62	-3.56**	T		
10	lni	I(0)	0	-2.25	-6.1	-4.13	T							
11	lnm0	I(1)	0	-2.57	-3.1	-4.13	Y	0	-2.45	-6.93	-3.56**	T		
12	lnm1	I(1)	1	-2.51	-3.47	-4.13	Y	0	-2.41	-6.98	-3.56**	T		
13	lnm2	I(1)	0	-3.98	-1.34	-3.49	Y	0	-4.01	-6.7	-3.56**	T		
14	lnmm	I(1)	0	-2.90	-2.15	-4.13	Y	0	2.83	-7.19	-3.56**	T		
15	lnp	I(1)	0	1.87	-3.61	-4.13	Y	0	2.03	-7.12	-3.56**	T		
16	lnqm	I(1)	0	-3.7	1.0	-3.43	Y	0	-3.67	-7.03	-3.56**	T		
17	lntd	I(1)	1	-3.1	2.43	-2.91	Y	0	-4.26	-5.23	-3.56**	T		
18	M0	I(1)	0	7.44	-3.25	-4.13	Y	0	7.65	-5.98	-3.56**	T		
19	dCIIC	I(0)	1	-1.7	-5.3	-4.14	T							
20	M1	I(1)	1	7.34	-3.17	-4.13	Y	0	7.45	-6.8	-3.56**	T		
21	M2	I(1)	0	7.91	1.16	-4.13	Y	0	8.1	-4.27	-3.56**	T		
22	dCR	I(0)	1	-1.88	-5.16	-4.14	T							
23	MM	I(1)	0	-1.13	-1.41	-4.13	Y	0	-1.98	-7.2	-3.56**	T		
24	Inf0	I(0)	1	5.0	-3.78	-3.49*	T							
25	Inf	I(0)	0	4.59	-4.18	-4.14	T							
26	dm0	I(0)	0	-2.42	-6.98	-4.14	T							
27	dm1	I(0)	0	-2.37	-6.97	-4.14	T							
28	dm2	I(0)	0	-3.93	-6.89	-4.14	T							
29	dqm	I(0)	1	-3.56	-5.49	-4.14	T							

- \*(\*\*)-тэмдэг нь ач холбогдлын 5% (1%)-ийн түвшинд нэгж язгууртай буюу тогтвортой бус байна гэсэн  $H_0$  таамаглалыг няцааж байгааг үзүүлнэ.
- I(0)-г шалгахдаа ADF тестиийн тэгшитгэлд хугацааны хандлага болон тогтмол гишүүнийг оруулан тооцсон.
- I(1)-г шалгахдаа ADF тестиийн 1-р эрэмбийн ялгаварт тэгшитгэлд зөвхөн тогтмол гишүүнийг оруулсан.
- Т ба Y үсгээр тухайн хүснэгтэд □тийм□ □үгүй□ гэсэн хариултыг төлөөлүүлэн тэмдэглэсэн.

Шинжилгээний аргын хувьд эдгээр тогтвортой бус үзүүлэлтүүдийн хувьд 1-р эрэмбийн ялгаврыг олж тогвортой үзүүлэлт болгох замаар регрессийн шинжилгээг хийх эсвэл тогтвортой бус байдлаар co-integration шинжилгээг хийх 2 боломжит хувилбар байж болох юм. Хугацааны хамаарлыг урт болон богино хугацааны

байдлаар салган харуулж, аливаа бодлогын болон гадаад хүчин зүйлсийн шокуудын нөлөөг тооцох боломжтой байдгаараа co-integration шинжилгээ давуу талтай гэж үздэг хэдий ч энэ судалгаанд хамрагдаж байгаа үзүүлэлтүүдийн динамик харьцангуй богино байгаа нь co-integration шинжилгээг үнэлэхэд хангалтгүй байж болох талтай тул 1-р эрэмбийн ялгаврыг олж тэгшигэлээ үнэлэх нь тохиромжтой гэж үзлээ.

### VIII. Загвар, хамаарлын эконометрик үнэлгээ :

Өмнөх бүлгүүэд тодорхойлсон загвар хамаарлуудыг бодит тоон өгөгдөл дээр шинжилж, өөрийн орны хувьд уг загвар, хамаарлыг ажлуулан мөнгөний бодлогын төлөвлөлт, тооцоололд ашиглаж болохыг харуулах нь энэхүү судалгааны үндсэн цөм хэсэг нь билээ. Энэ хэсэгт дээрх загвар, хамаарлуудыг үнэлгээг боломжит арга хэлбэрээр тодорхойлон, үнэлгээний үр дүнг тайлбарлах болно.

Загвар хамаарлыг үнэлэхдээ хувьсагчдын хоорондын функциональ хамаарлыг тодорхойлохдоо хамгийн энгийн хэлбэр буюу шугаман (натурал логарифм авсны дараа) функцээр авсан болно.

Эдгээр тэгшигэлүүдийг тодорхойлохдоо (Eviews 3.1 программыг ашиглан ) болоижит аргуудаар үнэлэн хооронд нь статистик шинжүүрүүдийг ашиглан харьцуулах замаар оновчтойг нь сонгосон.

Мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын системийн хамаарлыг тодорхойлохдоо шууд ХБКА-ыг хэрэглэх боломжгүй харин 3 алхамт ХБКА (3-SLS)-аар үнэлэх нь тохиромжтой гэж үзлээ. Учир нь бидний үнэлэх загвар нь бусад макро эдийн засгийн загваруудын нэгэн адил систем дотроос тодорхойлогдож байгаа үзүүлэлт нь бусад үзүүлэлтүүддээ нөлөөтэй байдаг бөгөөд энэ нь **feedback** механизм үүсэж байгаа учир үүнийг засварлан үнэлэх үнэлэгч нь 2 алхамт ХБКА (2-SLS) юм. Мөн энэ загварт гэнэтийн шокууд нь мөнгөний үзүүлэлтүүддэд шууд болон шууд бус байдлаар нэгэн зэрэг нөлөөлж болно. Өөрөөр хэлбэл системийн тэгшигэлүүдийн үлдэгдлүүд хоорондоо contemporaneous хамаараотай байна. Эдгээрээс үндэслэн 2 алхамт ХБКА дээр *Seemingly Unrelated Regression (SUR)* загварын таамаглалыг нэмж оруулсан үнэлэгч болох 3 алхамт ХБКА-аар үнэлсэн.

Манай орны хувьд хамаарах хувьсагчдыг оновтойгоор илэрхийлэх загварыг тодорхойлох нь зүйтэй юм. Бид тэгшигэл бүрийн үнэлгээг хийснээр тэгшигэлийн үлдэгдлийг засварлан үнэлгээг сайжруулах боломжтой байдагаараа давуу талтай байдаг. Хавсралтад тэгшигэл бүрийн боломжит алдаа багатай үнэлгээг харуулав.

#### **8.1 Мөнгөний үзүүлэлтийн хоорондын хамаарал**

$$\begin{aligned}
 br_t &= 18.3 + 0.344(td_{t-1} + dd_{t-1}) + 11.33dum4 \\
 \ln td_t &= -19.9 + 0.42 \ln cr_{t-1} + 0.96 \ln dd_{t-1} + 2.7 \ln er_{t-1} + 3dum3 \\
 \ln fd_t &= -26.83 + 0.39 \ln cr_{t-1} + 0.24 \ln dd_{t-1} + 4 \ln er_t + 0.84 \ln mm_t \\
 \ln qm_t &= -0.18 + 0.26 \ln dd_{t-1} + 0.15 \ln cr_{t-1} + 0.54 \ln fd_t + 0.26 \ln fd_{t-1} + 0.13 \ln mm_t \\
 \ln dd_t &= 18.9 + 0.27 \ln cbb_{t-1} + 0.74 \ln br_{t-1} + 0.63 \ln cr_{t-1} - 2.85 \ln er_{t-1}
 \end{aligned}$$

Энд хүүгийн үзүүлэлтүүд нь хувь, ln гэж тэмдэглэсэн бусад үзүүлэлтүүд нь тухайн хувьсагчийн натураль логарифмын утга юм. dum3 - 3-р улиралын dummy хувьсагч , dum 4- 4-р улиралын dummy хувьсагч

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

- Банкуудын нөөц буюу тэгшитгэл (7) нь судалгааны ажлын онолын хэсэгт тодорхойлсны дагуу банкуудын өмнөх сарын татан төвлөрүүлсэн хөрөнгөний 34.4 хувийг өөртөө багтааж байдаг байна.
- Дотоод төгрөгийн хадгаламж буюу тэгшитгэл (8) нь банкнаас гадуурх мөнгө, харилцахын үлдэгдэл, валютын ханшны өмнөх үеэс зэрэг хамааралтай байна. Энэ нь нийт мөнгөний хэмжээ нь өөрөө өссөнтэй холбоотой байж болох талтай . Эдгээрээс гадаад валютын ханш нь дотоод төгрөгийн хадгаламжид хамгийн их нөлөөтэй байна.
- Гадаад валютын хадгаламж буюу тэгшитгэл (9) нь загварт тодорхойлогдсон банкнаас гадуурх мөнгө, харилцах, валютын ханш болон мөнгөний үргүүлэгчтэй зэрэг хамааралтай байгаа бөгөөд эдгээрээс валютын ханш хамгийн хүчтэй байгаа нь Монголын үндэсний валютын ханш унах хандлага ажиглагдсанаас харилцагчид банкин дахь хадгаламжаа гадаад валютын хэлбэрээр төвлөрүүлэх болсонтой холбоотой.
- Бараг мөнгө буюу тэгшитгэл (10) нь загварт тодорхойлогдсон харилцах, банкнаас гадуурх мөнгө, гадаад валютын хадгаламж, өмнөх үеийн гадаад валютын хадгаламж болон мөнгөний үргүүлэгчтэй зэрэг хамааралтай байгаа нь тэгшитгэлийн үр дүнгээс харагдаж байна. Эдгээрээс гадаад валютын хадгаламж нь бараг мөнгөнд хамгийн их нөлөөтөй байна. Харин ТБҮЦ-ны хүү болон, зээлийн хүүгээс хамаардаггүй байна.
- Харилцах дахь мөнгө буюу тэгшитгэл (11) нь загварт тодорхойлогдсон ТБҮЦ-ны хэмжээ, банкуудын нөөц, банкнаас гадуурх мөнгөтэй зэрэг хамааралтай, валютын ханштай сөрөг хамааралтай байна. Эдгээрээс валютын ханш нь харилцах дахь мөнгөтэй хамгийн хүчтэй хамааралтай байгаа нь тэгшитгэлийн үр дүнгээс харагдаж байна. Харин зээлийн хүүтэй хамааралгүй байна.

Загварын үнэлэгдсэн коэффициентүүдийг эдийн засгийн утгынх нь хувьд хүлээж авах боломжтой байна. Тухайлбал : өмнөх үеийн банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах нь төгрөгийн хугацаатай хадгаламжид сувалтар нөлөөтэй бол өмнөх үеийн валютын ханш хүчтэй нөлөө үзүүлдэг нь харагдаж байна.

## **8.2 Инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал**

Үзүүлэлтүүдийн time series properties шинж чанарыг шалгасны дараа инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг үнэлэхэд дараахь үр дүн өгсөн.

### **Инфляци сарын өөрчлөлт үзүүлэлт inflation monthly changes**

Мөнгөний үзүүлэлт болон сарын инфляцийн өөрчлөлтийн хоорондын хамаарлыг гаргахдаа инфляцийг тайлбарлаж болох мөнгөний үзүүлэлт болон мөнгнөий талын үзүүлэлтүүдийн регресс үнэлэн хавсралтанд харуулав.

Үнэлгээнээс статистик шалгууруудын хувьд (AIC, SC, AR<sup>2</sup>) мөнгөний талын үзүүлэлтүүд нь инфляцийн сарын өөрчлөлтийг тайлбарлах чадвар бусдаасаа өндөр байгаа загвар нь дараах хэлбэрээр тодорхойлогдож байна.

$$\text{inf}_t = 0.36 \text{inf}_{t-1} + 0.21 \text{inf}_{t-2} - 0.224 \text{dm2}_{t-3} + 0.241 \text{dm2}_{t-7} + 1.05 \text{der}_{t-3} - 0.015 \text{dcbb}_{t-2} - 0.019 \text{dcbb}_{t-4}$$

Тэгшитгэлээс харахад бидэнд дараах мэдээллийг өгч байна.

- Инфляцийн сарын өөрчлөлт үзүүлэлтэд M2-мөнгөний өсөлт нь нөлөөтэй байгаа нь харагдаж байна.
- Дээрх тэгшитгэл дэхь валютын ханшны 3-р сарын хоцрогдол нь инфляцид хүчтэй нөлөөлж байгаа бөгөөд зэрэг хамааралтай байна.

\* Энэ судалгааны ажил нь Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 80 жилийн ойн судалгааны ажлын уралдаанд шалгарсан болно.

- 1, 2-р сарын өмнөх инфляци нь дараа сарын инфляцид эерэг нөлөөлөлтэй байна. Энэ нь инфляцийн хүлээлтийг бий болгодогийг нотолж байна.
- 2, 4-р сарын өмнөх ТБҮЦ-ий хүүгийн түвшин нь инфляцитай сөрөг нөлөөтэй байна.
- Дээрх үр дүнгүүдээс харахад M2 мөнгө нь 7 сарын хоцролттойгоор инфляцийг өсгөдөг гэсэн эдийн засгийн утгаа хадгалж байгаа боловч 3 сарын хоцролттойгоор инфляцийг бууруулдаг мэт үр дүн өгсөн байгаа нь бусад нөлөөлөгч хүчин зүйлс болох валютын ханш 3 сарын хугацааны хоцролттойгоор инфляцид нөлөөлдөггүй холбоотой байж болох талтай. Учир нь 3 сарын өмнөх инфляцид хамгийн их нөлөөтэй байгаа валютын ханшны бууралт нь инфляцийг буулгах хандлагтай байхад M2 мөнгөний өсөлттөй байсан ба валютын ханшны бууралт нь мөнгөний өсөлтөөс илүү инфляцид нөлөөтэй тул инфляцийг бууруулдаг байж болох юм. Ийм нөхцөлд бидний үнэлсэн регресс нь дээрх гажилттай тайлбарыг өгч болх үр дүн өгсөн байх талтай.
- Хэдийгээр дээрх үр дүнгүүд нь инфляцийг тайлбарлан монетарист хандлагыг баталгаажуулж байгаа боловч шинжилгээнд авсан түүврийн тоо харьцаангуй бага, ТТЭЗ-аас 33ЭЗ-руу шилжсэнтэй холбоотойгоор бүтцийн инфляции үссэн зэрэг шалтгаанаар бүрэн тайлбарлагдах боломж хомс юм.

Дээрх эргэлзээтэй үр дүнг бидэнд өгч байгаа тул M2 мөнгөний үзүүлэлтийн өсөлт болон оны эхнээс инфляцийн өөрчлөлтийн аль нь алиныхаа шалтгаан болж байгааг ялган харахын тулд Granger causality -г авч үзэх шаардлагатай боллоо.

